Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Залуучууд, насанд хүрэгчдийн гэр бүлийн боловсрол хариуцсан арга зүйч, мэргэжилтэн Агазай Ханат

2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Насан туршийн боловсролын бодлого, шийдвэр, арга хэмжээ, хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, үр дүнг тооцох, тайлагнах | | | | | | | |
| 1 | Насан туршийн суралцахуйн эрх зүйн орчныг сайжруулах баримт бичгүүдийн төсөлд санал өгөх. | Санал өгсөн баримт бичгийн тоо | Батлагдсан 3 журам, 1 дүрмийн төсөлд санал өгсөн | 3 | 1. Японы Хүүхдийн ивээх сангаас 5 аймгийн 25 суманд хэрэгжүүлсэн "Сургуульд суурилсан энтерпрайз" төсөл, Насан туршийн суралцахуйн төвүүдэд хэрэгжүүлсэн "Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтерпренершип боловсрол олгох" төслийн тогтвортой байдлыг хангаж, орон нутагт түгээн дэлгэрүүлэх тухай албан бичгийн төсөл, зөвлөмж боловсруулав. 2. БЕГ-ын даргын "Дархлаажуулалтын аян зохион байгуулах" тухай тушаалын төслийг боловсруулж, холбогдох албан тушаалтнуудад | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | танилцуулан зөвшөөрүүлж, удирдамжийг хавсралтаар батлуулан БЕГ-ын даргын 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/115 дугаар тушаалыг албажуулав<br>Хавсралт: 3 файл | | |
| 2 | Аймаг, дүүргийн НТСТ-ийн 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг шүүн шинжилж, гэр бүлийн боловсролтой холбогдолтой тоон мэдээллийг нэгтгэн дүгнэлт гаргах, цаашдын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох. | Шинжилгээний үр дүн, нэгтгэсэн тоон мэдээллийн тоо | 21 аймаг, 9 дүүргийнөвүүдийн гүйцэтгэлийн тайлан | 1 | 21 аймаг, 9 дүүргийн Насан туршийн суралцахуйн төвийн 2024 оны гүйцэтгэлийн тайланг нэг бүрчлэн уншиж, залуучууд, насанд хүрэгчдийн гэр бүлийн боловсролын чиглэлээр зохион байгуулсан сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа болон сургалтад ашигласан хэрэглэгдэхүүний талаарх мэдээллийг нэг талбарт оруулан нагтгэж, дүгнэлт гаргав.<br>Хавсралт: 1 файл | 1-р сар | 100% |
| 3 | НТСТ-ээс тухайн аймаг, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрөлжсөн асрамжийн газруудтай хамтран ажиллах чиглэлийг тодорхойлж, дэмжлэг үзүүлэх олон талт үйл ажиллагааг зохион байгуулах. | Хамтран ажилласан байгууллага, зохион байгуулсан үйл ажиллагааны тооны өсөлт, хувиар | 10% | 50% | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Төрөлжсөн асрамжийн газруудын асуудал хариуцсан мэргэжилтэнтэй холбоо тогтоож нийслэл болон зарим аймагт үйл ажиллагаа эрхэлдэг төрөлжсөн асрамжийн газруудын үйл ажиллагаа, онцлог, салбар хоорондын түншлэлийн талаар мэдээлэл авч, дүгнэлт хийж, аймаг, | 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дүүргийн Насан туршийн төвүүд эдгээр асрамжийн газруудтай холбоо тогтоож, сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах чиглэлийг тодорхойлсон. | | |
| 4 | Аймаг, дүүргийн НТСТ-ээс авсан Нөхцөл байдлын судалгааны мэдээллийг боловсруулж, үр дүнг нэгтгэн тайлан гаргах; залуучууд, насанд хүрэгчдийн гэр бүлийн боловсролын хэрэгцээг тандах судалгаа явуулах бэлтгэлийг хангах | Судалгааны тайлангийн боловсруулалтын түвшин, хувиар | Судалгааны мэдээлэл бэлэн болсон, 20% | 50% | Насан туршийн боловсролын тэргүүлэх чиглэл, төвүүдийн бүтэц орон тоо, ур чадварын нэмэгдэл, мэргэшлийн зэрэг олгох журам батлагдаж шинэ нөхцөл байдал үүссэн учраас аймаг, дүүргийн Насан туршийн суралцахуйн төвүүдээс авсан нөхцөл байдлын судалгааг нэгтгэж тайлан гаргах шаардлагагүй болсон. Залуучууд, насанд хүрэгчдийн гэр бүлийн боловсролын хэрэгцээг тандах судалгаа явуулах бэлтгэлийг хангаж, гэр бүлтэй холбогдолтой хууль эрх зүйн орчин болон шаардлагатай судалгааны мэдээлэл, онол, арга зүйн материалуудыг судалж байна.<br>Хавсралт: 6 файл | 5-р сар, 6-р сар, 9-р сар | 50% |
| 1.2. Насан туршийн суралцахуйн төвийн менежер, сумдын албан бус боловсролын багш нарыг арга зүйн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, иргэдийг тасралтгүй хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжих | | | | | | | |
| 5 | Аймаг, дүүргийн Насан туршийн суралцахуйн 4 төвийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйн | Гүйцэтгэлийн хувь | 2 | 30% | Баян-Өлгий аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн удирдлагын хүсэлтийн дагуу тус төвийн залуучууд, насанд хүрэгчдийн гэр бүлийн | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | удирдлагаар хангаж, зөвлөн туслах | | | | боловсролын асуудал хариуцсан багштай цахимаар холбогдож Гэр бүлийн боловсролын чиглэлээр сургалт явуулахдаа ашиглах PPT, монгол гэр бүлийн талаарх судалгааны материалууд болон гэр бүлийн хосуудын зан төлөвийн нийц, гэр бүлийн нягтрал, уян хатан байдал, гэр бүлийн харилцаанд өөрийн үнэлгээ өгөх зэрэг асуулга-тестүүдийг илгээж, хэрхэн бөглөх, үр дүнг үнэлэх, анхаарах асуудлуудын талаар зөвлөгөө өгөв. Хавсралт: 2 файл | сар, 11-р сар | |
| 6 | НТСТ-ийн менежер, сумдын албан бус боловсролын багш нарын мэргэжил, арга зүйн хөгжлийг дэмжих олон талт үйл ажиллагааг зохион байгуулах | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | Насан туршийн суралцахуйн 2 төв, 3 мэргэжилтэнд зөвлөн тусалсан | 1 | 1. 2025 оны 01 дүгээр сарын 22-оос 06 дугаар сарын 15-ныг хүртэл үргэлжилсэн Medle цахим сургуулийн "Хосолсон сургалтын арга зүй" сургалтын явцад Баян-Өлгий, Ховд, Увс аймаг, нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн суралцагчдын бүртгэл, ирц, идэвх, гэрийн даалгаврын биелэлт зэрэг зохион байгуулалтын асуудлыг хариуцаж, суралцагчдын нэрийг солих, нууц кодыг шинэчлэх гэх мэт үйлдлийг өдөр болгон олон удаа гүйцэтгэв. I бүсэд нийт 90 суралцагч хамрагдах | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ёстой боловч ажлаас гарсан, ЕБС-д шилжсэн, жирмэсний амралттай зэрэг хүндэтгэх шалтгаанаар 9 суралцагч хамрагдаж чадаагүй. 2. Нийслэлийн 9 дүүргийн удирдлага, менежер, багш 60 хүн оролцсон НҮБ-ийн Хүн амын сантай хамтран зохион байгуулсан "Хүний папиллома вирусын эсрэг дархлаажуулалт" сургалтад гэр бүлийн боловсролын эрх зүйн орчин, аймаг, дүүргийн НТСТ-ээс гэр бүлийн боловсролын чиглэлээр зохион байгуулж буй сургалтын үр дүнгийн талаар мэдээлэл өгч, хамтран ярилцав. Хавсралт: 1 файл | | |
| 7 | Насан туршийн суралцахуй, залуучууд, насанд хүрэгчдийн гэр бүлийн боловсролтой холбогдолтой эрх зүйн баримт бичиг, үйл ажиллагаа, онол, арга зүйн талаарх мэдээллийг олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх. | Сурталчилгааны мэдээллийн тоо | Олон нийтэд 5 удаа сурталчилгааны материал түгээсэн | 4 | Тайлангийн хугацаанд Боловсролын ерөнхий газрын пейжд албан тушаалын тодорхойлолт, үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд 5 удаа мэдээлэл байршуулсан. Үүнд: 1. БЕГ, МУБИС-тай хамтран зохион байгуулсан "Насан туршийн боловсрол 2.0" олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын үйл ажиллагаа, үр дүнгийн талаар. 2025.02.13-нд байршуулсан. 2. Мэргэжил сонгох аян эхэлсэнтэй холбогдуулан Мэргэжил | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сонгох томьёо мэдээлэл. 02.21 3. Наурызын баярын тухай танин мэдэхүйн болон багш нарт мэндчилгээ дэвшүүлсэн мэдээлэл. 03.22 4. 5 аймгийн 25 суманд хэрэгжсэн ESEL хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, цаашид түгээн дэлгэрүүлэх талаар. 04.15-нд байршуулсан 5. Хүний папиллома вирусын эсрэг дархлаажуулалтын аяны үр лүнгийн талаар мэдээлэл.05.29-нд илгээсэн<br>Хавсралт: 5 файл | | |
| 8 | E-Family платформыг идэвхтэй ашигладаг “Суралцагч гэр бүл” аяныг өрнүүлж, цахим орчинд гэр бүлийн олон талт үйчилгээ авах иргэдийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах. | Суралцагч гэр бүлийн тооны өсөлт | 0 | 0 | Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2025 оны II хагасаас эхлэн хэрэгжүүлэхээр тусгасан. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас боловсруулсан "Гэр бүлийн зөвлөгөө, үйлчилгээний E-Family цахим платформ хөгжүүлэх тухай удирдамж"-ийг судалж байна. | 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | 0% |
| 9 | Монгол гэр бүлтэй холбогдолтой статистик тоон мэдээллийг тасралтгүй баяжуулж, үйл ажиллагаанд ашиглах мэдээллийн бааз үүсгэх. | Статистик мэдээллийн баяжилтын хувь | 30% | 60% | Монгол гэр бүлтэй холбогдолтой шинээр гарсан статистик мэдээнүүдийг татан авч, нэгтгэн тухай бүрд нь ашиглах мэдээллийн баазтай болсон. Гэр бүлийн асуудлаар зохион байгуулсан "Гэр бүл хамгаалал-шийдэл" үндэсний хэлэлцүүлэгт оролцож, монгол гэр бүлийн | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар | 60% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өнөөгийн байдлын талаар шинэ мэдээлэл авсан. Хавсралт: 2 файл | | |
| 10 | Насан туршийн суралцахуйн төвийн багш нарт зориулсан гэр бүлийн боловсрол олгох цахим болон танхимын сургалтын гарын авлага боловсруулах бэлтгэлийг хангах үйл ажиллагааг зохион байгуулах. | Ажлын төлөвлөгөө, судалсан, цуглуулсан мэдээллийн баяжуулалт, хувиар | 0 | 30% | Гэр бүлийн боловсролын эрх зүйн орчин, гэр бүл судлаачдын судалгааны ном зохиол (Д.Х.Олсон, Дж.Портнер, И.Лави. М.Перре г.м), онол, арга зүйн материалууд, судалгааны тайлан, зарим төрлийн кейс, гэр бүлийн эв нэгдэл, нягтрал, уян хатан байдал, хосуудын харилцаа, хүүхдийн гэр бүлийн талаарх бодол санаа зэргийг оношлох тестүүдүүдийг цуглуулж, арга зүйн гарыг авлага боловсруулах бэлтгэлийг хангаж байна. Хавсралт: 1 файл | 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | 30% |
| 3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах | | | | | | | |
| 11 | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, | Биелэлтийн хувь | 10% | 50% | 1. "Жендэрийн тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө"-ний 1.1.12. "Сургууль завсардсан охид, хөвгүүд, өрх толгойлсон залуу эмэгтэйчүүдийг дахин суралцуулах, мэргэжил олгоход шаардлагатай дэмжлэг үзүүлнэ" гэсэн заалтын хэрэгжилтийг хангах ажлын гүйцэтгэлийн мэдээг нэгтгэв. 2. БЕГ, МУБИС-ийн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | албан тушаалтанд хүргүүлэх | | | | хамтран зохион байгуулсан "Насан туршийн суралцахуй 2.0" олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд хэлэлцүүлсэн 34 илтгэлийн англи хэл дээрх 8 илтгэлийн хураангуйг монгол хэлэнд орчуулж нэгтгэн, НТСТ-ийн төвийн албан хаагчдыг насан туршын боловсролын орчин үеийн чиг хандлагын талаарх мэдээллээр хангав. 3. Аймаг, дүүргийн НТСТ-ийн 2024 оны сүүлийн хагас, 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг уншиж, Насан туршийн суралцахуйн 2024-2025 оны зорилго, зорилтын хэрэгжилтийг нэгтгэн гаргаж ЗУГ-д хүргүүлэв. 4. НТСТ-ээс насан туршийн суралцахуйн хүний нөөцийг хөгжүүлэх, албан бус боловсролын багш нарыг чадавхжуулах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлыг нэгтгэн гаргав. 5. "Хүний папиллома вирусын эсрэг дархлаажуулалтын аян"-ы тайланг нэгтгэж, НҮБ-ийн ХАС-г мэдээллэр хангав. 6.Өөрт хувиарлагдсан аймаг, дүүргийн НТСТ-ийн 2025 оны I улирлын гүйцэтгэлийн тайлан, төвийн захирлын гүйцэтгэлийн тайланг уншиж үнэлгээ өгөв. 7. ЕБС-ийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | багш нарын гүйцэтгэлийн үнэлгээний шалгалтын сэдэв боловсруулах ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж, хос хэлээр сургалт явуулдаг сургуулийн казах хэл, уран зохиолын хичээлийн 15 сэдэв боловсруулж, бага боловсролын 6 хичээлийн 20 сэдвийг монгол хэлнээс казах хэлэнд орчуулав. 8. АХБ-ны санхүүжилтээр хэрэгжсэн "Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл"-ийн хүрээнд зохион байгуулсан "Насан хүрэгчдийн мэдээлэл харилцаа холбоо, технологийн боловсролын жишиг хөтөлбөр" боловсруулах үйл ажиллагааны тайлангийн 4.1 хэсгийг сайжруулан боловсруулав. Хавсралт: 7 файл | | |
| 12 | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон | Биелэлтийн хувь | 0 | 50%. | Хууль тогтоомжид заасан чиг үүргийг 100% мөрдөж ажиллав. | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан чиг үүргийг 100% хэрэгжүүлж ажиллах. | | | | | сар, 12-р сар | |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Үндэсний бичгийн мэдлэгээ ахиулж, албан хэргийг хос бичгээр хөтлөх чадвараа дэмжих сургалтад хамрагдах, мэдлэг чадвараа бие даан сайжруулах. | Биелэлтийн хувь | 10% | 40% | Анхан, дунд шатны цахим хичээл болон цахим сурах бичгийг ашиглан бие даан суралцаж, унших, бичих чадвараа ахиулсан Хавсралт: 1 файл | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |
| 2 | Ажил үүргийн холбогдолтой шинээр батлагдсан хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийг судлах. | Шинээр батлагдсан эра зүйн баримт бичгүүдийг тухай бүрд нь судалж, тэмдэглэл хөтөлсөн байна. Биелэлтийн хувь | 30% | 50% | Нийгмийн даатгалын тухай, Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийн хэрэгжилт, Хэвлэмэл болон цахим сурах | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бичгийн стандартын тухай сургалт хэлэлцүүлэгт оролцож, Гэр бүлийн тухай, Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төсөл, Хос хэлний боловсролын талаар баримтлах чиглэл, 2026 оныг Боловсролыг дэмжих жил болгон зарласантай холбоотой мэдээ, мэдээллүүд зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг уншиж судлав. | сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | |
| 3 | Залуучууд, насанд хүрэгчдийн гэр бүлийн боловсролын талаарх онол, арга зүйн мэдлэгээ тасралтгүй дээшлүүлж, тухайн чиглэлээр олон улсын чиг хандлагыг судлах. | Гэр бүлийн тухай хуулийн төсөл, Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яамаас шинээр батлагдсан дүрэм, журам болон гэр бүлийн харилцааг зохицуулсан бусад эрх зүйн баримт бичгүүд; гэр бүлийн боловсролын талаарх олон улсын сайн туршлагыг судалсан байна. Биелэлтийн хувь | 20% | 60% | Гэр бүлийн тухай, Гэр бүлийг дэмжих тухай хуулийн төсөл, гэр бүлийн харицаатай холбогдолтой батлагдаж гарсан журам, дүрмийг уншиж судлав. Дундад Азийн болон зүүн Европын зарим орны гэр бүлийн талаар баримталж буй бодлого, гэр бүлийн боловсролын талаарх сайн туршлагыг судлав. | 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар | 60% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Залуучууд, насанд хүрэгчдийн гэр бүлийн боловсрол хариуцсан арга зүйч, мэргэжилтэн, Агазай Ханат /................................................/
Огноо: .........................